



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1/33

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Сумын 2022 оны төсөв батлах тухай” 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрөө тохижуулах” ажлын санхүүжилтэд 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрөө тохижуулах” ажлын санхүүжилтэд зарцуулагдах 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ